

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төмөр замын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/213/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:51-261663 Цахим хаяг: <a href="mailto:naranchimegts@audit.gov.mn">naranchimegts@audit.gov.mn</a> Аудитын менежер: Д.Энхдалай Утас:51-260512 Цахим хаяг: <a href="mailto:enkhdalaid@audit.gov.mn">enkhdalaid@audit.gov.mn</a> Ахлах аудитор: Ц.Энхжаргал Утас:51-261628 Цахим хаяг: <a href="mailto:enhkjargalts@audit.gov.mn">enhkjargalts@audit.gov.mn</a> Аккаунт траст аудит ХХК-ийн захирал: П.Наранцэцэг Цахим хаяг: <a href="mailto:acctrust.audit@gmail.com">acctrust.audit@gmail.com</a>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b>	<b>3</b>
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b>	<b>5</b>
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b>	<b>12</b>
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.5.1 Төсвийн төлөвлөлт	14
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	15
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	16
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b>	<b>16</b>
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b>	<b>19</b>
5.1 Албан шаардлага	19
5.2 Зөвлөмж	20
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b>	<b>21</b>

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УИХ	Улсын их хурал
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/368

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төмөр замын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Засгийн Газрын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 73 дугаар тогтоолоор Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг Төмөр замын газрыг байгуулж, Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв УТҮГ-ын орон тоо, үндсэн хөрөнгө, Зам тээврийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газар болон Салбарын хяналтын газрын төмөр замын асуудал хариуцсан зарим албан хаагчдыг чиг үүрэг, цалингийн сан, тоног төхөөрөмж, бусад эд хөрөнгийн хамт Төмөр замын газарт тус тус шилжүүлсэн байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

БНСУ-ын олон улсын хамтын ажиллагааны байгууллага (Койка)-ын 14,000.0 мянган ам долларын төслийн хөрөнгө оруулалтаар Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн барилгыг барих төсөл 2021-2026 онд хэрэгжиж, барилгыг 2026 онд улсын комисст хүлээлгэж өгөхөөр ажиллаж байна.

### **Бусад асуудал**

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төмөр замын газар 2025 онд дараах онцлох ажлуудыг гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Гашуунсухайт–Ганцмод чиглэлийн хил дамнасан төмөр замын төслийн бүтээн байгуулалтын ажил 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдөр албан ёсоор эхэлсэн;
- “Замын-Үүд-Эрээн боомтын 1435 мм царигтай хоёр дахь замыг хамтран барих тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төслийг харилцан баталгаажуулсан;
- Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 21, 86 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулж төслийн нээлтийг зохион байгуулж бүтээн байгуулалтыг ажлыг дотоодын 70 аж ахуй нэгж байгууллага, 3000 инженер, техникийн ажилтнууд, 1500 техник хэрэгсэл, машин механизмтай ажиллаж замын доод бүтцийн барилга угсралтын ажлыг 96 хувьтай гүйцэтгэсэн;
- Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объект, үйл ажиллагааны гэрчилгээ хүссэн иргэн, хуулийн этгээдийн өргөдөл хүсэлтийг цахимаар хүлээн авч, нийт 727 өргөдөл, хүсэлтийг шийдвэрлэж, 142 салбар зам, 1928 хөдлөх бүрэлдэхүүн, 73 үйл ажиллагаа, нийт 2143 объект, үйл ажиллагааг гэрчилгээжүүлсэн;
- Төмөр замын тээврийн 24 дүрэм, журмын төслийг боловсруулж 10 журам, стандартыг батлуулсан.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>7,286,091.00</b>	<b>10,188,190.00</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	60,000.00	-
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	60,000.00	-
3351	Байгууллагаас авах авлага	60,000.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	7,226,091.00	10,188,190.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	7,033,591.00	9,840,830.00
35110	Тусгай зориулалттай материал	7,033,591.00	9,840,830.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	192,500.00	347,360.00
35410	Бичиг хэргийн материал	192,500.00	347,360.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,412,202,108.02</b>	<b>3,323,679,902.28</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	3,412,202,108.02	3,323,679,902.28
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,637,447,108.02	1,542,741,568.96
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,632,890,029.00	1,632,890,029.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(108,859,335.24)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	57,338,000.00	267,038,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(57,338,000.00)	(267,038,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	9,348,938.00	53,477,684.62
39206	Хуримтлагдсан элэгдэл	(6,795,250.00)	(36,249,299.10)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	6,062,430.95	5,388,844.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	(4,059,039.93)	(3,906,355.12)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	1,774,755,000.00	1,780,938,333.32
39301	Програм хангамж	85,551,000.00	7,670,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(84,781,000.00)	(716,666.68)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,773,985,000.00	1,773,985,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>3,419,488,199.02</b>	<b>3,333,868,092.28</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>894,417.00</b>	<b>4,473,889.86</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	894,417.00	4,473,889.86
<b>413</b>	<b>Өглөг</b>	894,417.00	4,473,889.86
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	894,417.00	4,473,889.86
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,418,593,782.02</b>	<b>3,329,394,202.42</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	3,418,593,782.02	3,329,394,202.42
511	Засгийн газрын оруулсан капитал	1,615,360,000.00	1,615,360,000.00
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	1,615,360,000.00	1,615,360,000.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,803,233,782.02</b>	<b>1,714,034,202.42</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	1,803,233,782.02	1,803,233,782.02
51220	Тайлант үеийн үр дүн	-	(89,199,579.60)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>3,419,488,199.02</b>	<b>3,333,868,092.28</b>

Төмөр замын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн аудитын тайлан

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,686,793,808.02</b>	<b>1,604,598,911.78</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,638,217,108.02</b>	<b>24,514,611.78</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,638,217,108.02	24,514,611.78
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,327,079.02	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5,327,079.02	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,048,576,700.00</b>	<b>1,580,084,300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,048,576,700.00	1,580,084,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,048,576,700.00	1,580,084,300.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,055,325,658.30</b>	<b>1,693,798,491.38</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,055,325,658.30</b>	<b>1,693,798,491.38</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,021,062,337.75</b>	<b>1,649,275,469.52</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>728,743,504.02</b>	<b>1,239,246,769.14</b>
210101	Үндсэн цалин	416,933,734.42	582,925,745.41
210102	Нэмэгдэл	153,478,417.80	264,545,792.99
210103	Унаа хоолны хөнгөлөлт	52,759,741.63	243,402,050.67
210104	Урамшуулал	105,571,610.17	148,373,180.07
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>95,600,517.00</b>	<b>156,671,772.86</b>
210201	Тэтгэврийн даатгал	64,400,100.00	113,440,266.74
210202	Тэтгэмжийн даатгал	7,576,500.00	9,892,857.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,788,200.00	8,521,618.15
210204	Ажилгүйдлийн даатгал	3,788,300.00	4,952,318.15
210205	Эрүүл мэндийн даатгал	16,047,417.00	19,864,712.58
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>90,720,000.00</b>	<b>58,366,300.00</b>
210304	Байрны түрээс	90,720,000.00	58,366,300.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>34,388,574.23</b>	<b>29,873,801.00</b>
210401	Бичиг хэрэг	9,987,800.00	11,915,440.00
210402	Тээвэр, шатахуун	8,530,000.00	2,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,483,646.23	8,141,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,664,200.00	283,270.00
210408	Бараа материал акталсны зардал	4,722,928.00	7,033,591.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>11,705,400.00</b>	<b>1,948,695.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,095,400.00	1,798,570.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	610,000.00	150,125.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,400,000.00</b>	<b>210,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,400,000.00	210,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>53,249,272.00</b>	<b>43,021,314.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,348,692.00	12,400,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,452,500.00	2,250,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	376,200.00	847,000.00

**Төмөр замын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн аудитын тайлан**

210804	Тээврийн хэрэгслийн татвар	30,000.00	43,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	45,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	34,804,800.00	21,897,840.00
210807	Газрын төлбөр	3,531,600.00	3,098,774.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	2,058,300.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,705,480.00	381,400.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>5,255,070.50</b>	<b>119,936,817.52</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,905,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	350,070.50	119,936,817.52
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>34,263,320.55</b>	<b>44,523,021.86</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>4,900,000.00</b>	<b>250,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,900,000.00	250,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	<b>44,273,021.86</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	44,273,021.86
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>29,363,320.55</b>	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,363,320.55	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>1,631,468,149.72</b>	<b>(89,199,579.60)</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	-	-
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	8,436,200.00	-
225002	Найдваргүй авлагын алдагдал	8,436,200.00	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(8,436,200.00)	-
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>1,623,031,949.72</b>	<b>(89,199,579.60)</b>

Төмөр замын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн аудитын тайлан

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,048,576,700.00</b>	<b>1,580,084,300.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,048,576,700.00</b>	<b>1,580,084,300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,048,576,700.00	1,580,084,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,048,576,700.00	1,580,084,300.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,048,576,700.00</b>	<b>1,580,084,300.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,048,576,700.00</b>	<b>1,580,084,300.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,014,313,379.45</b>	<b>1,535,561,278.14</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>728,947,361.22</b>	<b>1,239,246,769.14</b>
210101	Үндсэн цалин	417,137,591.62	582,925,745.41
210102	Нэмэгдэл	153,478,417.80	264,545,792.99
210103	Унаа хоолны хөнгөлөлт	52,759,741.63	243,402,050.67
210104	Урамшуулал	105,571,610.17	148,373,180.07
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>94,706,100.00</b>	<b>153,092,300.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	64,400,100.00	101,675,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,576,500.00	11,961,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,788,200.00	9,550,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,788,300.00	5,980,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	15,153,000.00	23,923,700.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>65,078,100.00</b>	<b>58,366,300.00</b>
210304	Байрны түрээс	65,078,100.00	58,366,300.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>22,670,646.23</b>	<b>23,303,400.00</b>
210401	Бичиг хэрэг	4,905,000.00	10,476,000.00
210402	Тээвэр, шатахуун	6,830,000.00	2,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,483,646.23	8,081,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,452,000.00	2,245,900.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>17,282,800.00</b>	<b>5,795,695.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,672,800.00	5,198,570.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	610,000.00	597,125.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,400,000.00</b>	<b>210,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,400,000.00	210,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>79,323,372.00</b>	<b>55,546,814.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	36,422,792.00	12,400,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,452,500.00	2,250,000.00

**Төмөр замын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210803	Даатгалын үйлчилгээ	376,200.00	847,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	30,000.00	43,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	45,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	34,804,800.00	32,557,540.00
210807	Газрын төлбөр	3,531,600.00	3,098,774.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	2,509,600.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,705,480.00	1,795,900.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>4,905,000.00</b>	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,905,000.00	-
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>34,263,320.55</b>	<b>44,523,021.86</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	4,900,000.00	250,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,900,000.00	250,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	44,273,021.86
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	44,273,021.86
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	29,363,320.55	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,363,320.55	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	-	-
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	-
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,615,360,000.00</b>	<b>180,201,832.30</b>	<b>1,795,561,832.30</b>
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,615,360,000.00</b>	<b>180,201,832.30</b>	<b>1,795,561,832.30</b>
C07	Тайлант үеийн үр дүн	-	1,623,031,949.72	1,623,031,949.72
C08	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,615,360,000.00</b>	<b>1,803,233,782.02</b>	<b>3,418,593,782.02</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,615,360,000.00</b>	<b>1,803,233,782.02</b>	<b>3,418,593,782.02</b>
D08	Тайлант үеийн үр дүн	-	(89,199,579.60)	(89,199,579.60)
D09	<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,615,360,000.00</b>	<b>1,714,034,202.42</b>	<b>3,329,394,202.42</b>

Төмөр замын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн аудитын тайлан

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дд	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>I</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>1,580,084,300.00</b>	<b>1,535,811,278.14</b>	<b>44,273,021.86</b>	<b>97.2</b>
3	Улсын төсвөөс санхүүжих	1,580,084,300.00	1,535,811,278.14	44,273,021.86	97.2
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,580,084,300.00</b>	<b>1,535,811,278.14</b>	<b>44,273,021.86</b>	<b>97.2</b>
<b>3</b>	<b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,580,084,300.00</b>	<b>1,535,811,278.14</b>	<b>44,273,021.86</b>	<b>97.2</b>
<b>4</b>	<b>Бараа, үйлчилгээний зардал</b>	<b>1,579,834,300.00</b>	<b>1,535,561,278.14</b>	<b>44,273,021.86</b>	<b>97.2</b>
<b>5</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,281,054,000.00</b>	<b>1,239,246,769.14</b>	<b>41,807,230.86</b>	<b>96.7</b>
6	Үндсэн цалин	724,245,400.00	582,925,745.41	141,319,654.59	80.5
7	Нэмэгдэл	280,049,000.00	264,545,792.99	15,503,207.01	94.5
8	Унаа, болон бусад нөхөн олговор	133,813,000.00	243,402,050.67	(109,589,050.67)	181.9
9	Урамшуулал	142,946,600.00	148,373,180.07	(5,426,580.07)	103.8
<b>11</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>153,092,300.00</b>	<b>153,092,300.00</b>	-	<b>100.0</b>
12	Тэтгэврийн даатгал	101,675,700.00	101,675,700.00	-	100.0
13	Тэтгэмжийн даатгал	11,961,800.00	11,961,800.00	-	100.0
14	ҮОМШӨ ний даатгал	9,550,200.00	9,550,200.00	-	100.0
15	Ажилгүйдлийн даатгал	5,980,900.00	5,980,900.00	-	100.0
16	Эрүүл мэндийн даатгал	23,923,700.00	23,923,700.00	-	100.0
<b>17</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>58,366,300.00</b>	<b>58,366,300.00</b>	-	<b>100.0</b>
21	Байрны түрээс	58,366,300.00	58,366,300.00	-	100.0
<b>22</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>23,303,400.00</b>	<b>23,303,400.00</b>	-	<b>100.0</b>
23	Бичиг хэрэг	10,476,000.00	10,476,000.00	-	100.0
24	Тээвэр (шатахуун)	2,500,000.00	2,500,000.00	-	100.0
25	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	8,081,500.00	8,081,500.00	-	100.0
28	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	2,245,900.00	2,245,900.00	-	100.0
<b>34</b>	<b>Эд хогшил худалдан авах</b>	<b>5,795,900.00</b>	<b>5,795,695.00</b>	<b>205.00</b>	<b>100.0</b>
35	Багаж, техник, хэрэгсэл	4,895,900.00	5,198,570.00	(302,670.00)	106.2
37	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	900,000.00	597,125.00	302,875.00	66.3
<b>39</b>	<b>Томилот, зочны зардал</b>	<b>300,000.00</b>	<b>210,000.00</b>	<b>90,000.00</b>	<b>70.0</b>
41	Дотоод албан томилот	300,000.00	210,000.00	90,000.00	70.0

**Төмөр замын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн аудитын тайлан**

<b>43</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр</b>	<b>56,422,300.00</b>	<b>55,546,814.00</b>	<b>875,486.00</b>	<b>98.4</b>
44	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,400,000.00	12,400,000.00	-	100.0
45	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	2,250,000.00	2,250,000.00	-	100.0
46	Даатгалын үйлчилгээ	900,000.00	847,000.00	53,000.00	94.1
47	Тээврийн хэрэгслийн татвар	450,000.00	43,000.00	407,000.00	9.6
48	Тээврийн хэрэгслийн оношилгоо	45,000.00	45,000.00	-	100.0
49	Мэдээллийн технологийн зардал	32,558,000.00	32,557,540.00	460.00	100.0
50	Газрын төлбөр	3,150,000.00	3,098,774.00	51,226.00	98.4
51	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	2,873,400.00	2,509,600.00	363,800.00	87.3
52	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,795,900.00	1,795,900.00	-	100.0
<b>53</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,500,000.00</b>	<b>-</b>	<b>1,500,000.00</b>	<b>-</b>
55	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,500,000.00	-	1,500,000.00	-
<b>66</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>250,100.00</b>	<b>250,000.00</b>	<b>100.00</b>	<b>99.96</b>
70	Бусад урсгал шилжүүлэг	250,100.00	250,000.00	100.00	99.96
73	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	250,100.00	250,000.00	100.00	99.96
133	АЖИЛЛАГСДЫН ТОО	25	25	-	<b>100.0</b>
134	Удирдах ажилтан	1	1	-	<b>100.0</b>
135	Гүйцэтгэх ажилтан	24	24	-	<b>100.0</b>

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төмөр замын газар нь Монгол улсын хууль тогтоомж, хөгжлийн бодлогын баримт бичиг, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний хөтөлбөрт төмөр замын тээврийн талаар тусгагдсан зорилт, арга хэмжээний зохицуулалтыг хэрэгжүүлэх, салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийг хууль тогтоомжийн хүрээнд удирдлага зохицуулалтаар хангах, тээврийн аюулгүй байдлыг хангуулах, үйл ажиллагаатай холбоотой хяналт тавих, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжсэн үйл ажиллагааны ил тод, шуурхай байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлдэг Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Төмөр замын газар эрхэм зорилгоо “Эдийн засгийн өсөлтийг тэтгэх, эрэлт нийлүүлэлтийн тэнцвэрийг хангах, дэвшилтэт шинэ технологид суурилсан төмөр замын тээврийн сүлжээг өргөжүүлэн хөгжүүлж, төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг ханган хэрэглэгчийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн аюулгүй, ая тухтай, хямд, өрсөлдөхүйц чанартай, өндөр бүтээмжтэй, үр ашигтай, байгаль орчинд ээлтэй төмөр замын тээврийн үйлчилгээг бий болгоход оршино.” гэж тодорхойлсон байна.

Төмөр замын газар нь тайлант онд дараах 10 зорилтын хүрээнд 57 арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Төмөр замын тээврийн хэмжээг нэмэгдүүлэх;
- Хил дамнасан төмөр замуудын бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх;
- Төмөр замын сүлжээг өргөтгөж, 3200 км орчим төмөр замын бүтээн байгуулалтыг эхлүүлэх;
- Төмөр замын сүлжээний ашиглалтын бэлэн байдлыг хангах;
- Төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй, түргэн шуурхай болгож цахимжуулж чанар хүртээмжийг сайжруулах;
- Төмөр замын тээврийн салбарын хөгжлийг дэмжсэн эрх зүйн орчинг бүрдүүлэх;
- Суурь бүтэц хоорондын галт тэрэгний хөдөлгөөнийг захирамжлан зохион байгуулах;
- Төмөр замын тээврийн статистик мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж хөтлөх;
- хөдлөх бүрэлдэхүүнд дугаар олгож, бүртгэл мэдээллийг хөтлөх;
- төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хэрэгжүүлж, эрх зүйн зохицуулалтыг хангаж, санхүү, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг зохицуулж, хэрэгжүүлэх.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус газар нь үйл ажиллагаандаа Төмөр замын тээврийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
- УИХ-ын 2025 оны “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-д нэмэлт оруулах тухай 13 дугаар тогтоол;

**Төмөр замын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

- Засгийн газрын 2025 оны “Төмөр замын газар байгуулах тухай” 73 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2025 оны “Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 52 дугаар тогтоол;
- Зам, тээврийн сайдын 2025 оны “Агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц шинэчлэн батлах тухай” А/277 дугаар тушаал.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төмөр замын газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна. Төмөр замын газар нь Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулах нэгдсэн төвийн захирлын 2024 оны 08 дугаар сарын 15-ны А/36 дугаар тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Төмөр замын газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 78,279.6 мянган төгрөгөөр буюу 2.9 хувиар буурсан байна.

#### *Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>Б</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3=2-1</b>
Авлага	60.0		(60.0)
Бараа материал	7,226.1	10,188.2	2,962.1
Үндсэн хөрөнгө	3,412,202.1	3,323,679.9	(88,522.2)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,419,488.2</b>	<b>3,333,868.1</b>	<b>(85,620.1)</b>
Өр төлбөр	894.4	4,473.9	3,579.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,418,593.8	3,329,394.2	(89,199.6)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>3,419,488.2</b>	<b>3,333,868.1</b>	<b>(85,620.1)</b>

Дээрх хүснэгтээс харахад дараах данснуудад нөлөө бүхий өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Бараа материал дансны үлдэгдэл 10,188.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,962.1 мянган төгрөгөөр өссөн нь оффисын хөшиг, серверийн төхөөрөмж худалдан авсантай холбоотой;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,323,679.9 мянган төгрөг болж, 88,522.2 мянган төгрөгөөр буурсан нь ТӨБЗГ-ын 2025 оны 26 дугаар тогтоолоор ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 17 нэрийн нийт 92,144.7 мянган төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг акталж данснаас хасч, 119,936.8 мянган төгрөгийн элэгдэл байгуулсантай тус тус холбоотой байна. Мөн ТӨБЗГ-ын 2025 оны 273 тоот тогтоолоор 159,800.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй 154,103.4 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхийн Ланд круйзер 200 /5608УНУ/ маркийн автомашиныг, 621 тоот тогтоолоор 49,900.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй 48,652.5 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхийн Hyundai sonata LF 10-16 УНУ маркийн автомашиныг, 622 дугаар тогтоолоор 50,818.9 мянган төгрөгийн балансын үнэ, 33,248.3 мянган төгрөгийн элэгдэл бүхий хөрөнгийг тус тус шилжүүлэн авч бүртгэсэн, 6,900.0 мянган төгрөгийн программ худалдан авсан байна;
- Өр төлбөр дансны үлдэгдэл 4,473.9 мянган төгрөг болж 3,579.5 мянган төгрөгөөр өссөн нь нийгмийн даатгалд төлөх өглөг нэмэгдсэн;
- Засгийн газрын хувь оролцооны дүн 3,329,394.2 мянган төгрөг болж 89,199.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнтэй холбоотой байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардал, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,508,721.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төслийн саналыг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн шууд захирагчаас ирүүлсэн төсвийн төслийн саналаас цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 537,343.1 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 446,135.8 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардлыг 384,085.5 мянган төгрөг, томилолт, зочны зардлыг 306,364.0 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 254,730.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллыг 150,100.0 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 148,156.3 мянган төгрөг, нийгмийн хамгааллын шимтгэлийн зардлыг 65,613. мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 37,600.0 мянган төгрөг, нормативт зардлыг 8,500.0 мянган төгрөгөөр тус тус бууруулж, нийт 1,170,093.0 мянган төгрөгөөр баталжээ.

Засгийн газрын 2025 оны 73 дугаар тогтоолоор “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг - Төмөр замын газар” байгуулагдсантай холбогдуулж, Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв УТҮГ-ын тайлант оны батлагдсан төсвийг Төмөр замын газарт шилжүүлж, 411,408.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 3 арга хэмжээг санхүүжүүлэх 1,580,084.3 мянган төгрөгийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,580,084.3 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, 44,273.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,535,811.3 мянган төгрөг буюу 97.2 хувьтай байгаа нь Үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 44,272.9 мянган төгрөгөөр, ажил олгогчоос олгох тэтгэмжийн зардлын төсвийг 0.1 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	<b>71103 Төмөр зам</b>	<b>1,580,084.3</b>	<b>1,535,811.3</b>	<b>44,273.0</b>	97.2
1.1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	1,567,434.2	1,523,161.3	44,272.9	97.2
1.2	80802- Ажил олгогчоос олгох тэтгэмж	250.1	250.0	0.1	99.9
1.3	81569-Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	12,400.0	12,400.0	-	100.0

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан дараах асуудлаар судалгаа авч, үр дүнг аудитын тайланд тусгалаа. Үүнд:

- Засгийн газрын 2025 оны 73 дугаар тогтоолоор Төмөр замын газрын орон тоог 48 байхаар тогтоож, Зам, тээврийн сайдын 2025 оны “Агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц батлах тухай” А/69 дүгээр тушаалаар Төмөр замын газрын зохион байгуулалтын бүтцийг 6 газар, 2 хэлтэстэй байхаар баталсан байна. Засгийн газрын 2025 оны “Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 52 дугаар тогтоолоор тус газрын орон тоог шинэчлэн тогтоож, үндсэн орон тоо 35, гэрээт албан хаагч 3 нийт 38 орон тоотой болсон байна.
- Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулах нэгдсэн төвийн захирлын 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/102 тоот тушаалаар хоол, унааны зардлын хэмжээг ажлын нэг өдөрт 34.0 мянган төгрөгөөр баталсан байна. Төмөр замын газрын даргын 2025 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/28 тушаалаар баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”-д хоолонд 34.0 мянган төгрөг, унаанд 3.0 мянган төгрөгийн хөнгөлөлт олгохоор тусгасан байна. Тайлант онд нийт 243,402.0 мянган төгрөгийн унаа, хоолны хөнгөлөлт ажилчдад олгосон байна.
- Тус газар нь тайлант онд Промакс ХХК-аар 6,900.0 мянган төгрөгөөр Байгууллагын цахим хуудас хийлгэж биет бус хөрөнгөөр бүртгэсэн байна. ТӨБЗГ-ын 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 26 дугаар тогтоолоор ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 561.0 мянган төгрөгийн цаг бүртгэлийн төхөөрөмж, 14,250.0 мянган төгрөгийн бүртгэл хөтлөх программ, 24,385.0 мянган төгрөгийн хөдлөх бүрэлдэхүүн бүртгэлийн программ, 20,750.0 мянган төгрөгийн суурь бүтцийн бүртгэлийн программ, 20,835.0 мянган төгрөгийн гэрчилгээжүүлэлтийн бүртгэлийн программ, 4,000.0 мянган төгрөгийн Веб сайт нийт 84,781.0 мянган төгрөгийн программыг акталсан байна.

- Тайлант онд гадаад томилолт, арга хэмжээний зардал, сургалт, семинар, хурал, зөвлөгөөний зардал, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээний төлбөр, төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардлууд гараагүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Тайлант онд худалдан авах ажиллагааны төсөв батлаагүй байна.

### **4. АУДИТЫН ТАЙЛАН**

#### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төмөр замын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Төмөр замын газар түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлэх арга хэмжээ авахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тайланд тусгасан болно.

Аудитыг Аккаунт траст ХХК-ийн ахлах аудитор Ч.Замбага, аудитор Р.Цогзолмаа, туслах аудитор П.Саранчимэг нар гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг захирал П.Наранцэцэг, чанарын хяналтын менежер Д.Эрдэнэтуяа, дараагийн шатны хяналтыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ц.Энхжаргал, аудитын менежер Д.Энхдалай, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Төмөр замын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 02/74 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны нийт зардлын 1,063,761.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 10,637.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан байгууллагын хангамж болон үйл ажиллагаанд тавих хязгаарлалтуудыг мөрдөж, хэмнэлтийн горимыг баримтлан ажилласнаар цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 41,807.3 мянган төгрөг, эд хогшил худалдан авах зардлыг 0.2 мянган төгрөг томилолтын зардлыг 90.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 1,500.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 875.5 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 496,691.4 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 496,691.4 мянга төгрөгийн 4 гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь “Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална” 4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, зардлын дансанд горим, сорил хэрэгжүүлж, илэрсэн алдаа зөрчлийг аудитын тайланд тусгалаа.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 35,337.4 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 13,875.7 мянган төгрөгийн зөрчилд 2 акт тогтоож, 12,600.0 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 8,861.7 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгсөн. Хэрэгжилтийг хянаж үзэхэд 2 төлбөрийн акт, 3 албан шаардлагын биелэлт 100.0 хувь, 4 зөвлөмжийн биелэлт 75.0 хувь, нийт шийдвэрийн хэрэгжилт 88.9 хувьтай байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

Д.д	Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
1	Төлбөрийн акт	2	13,875.7	2	13,875.7	100.0
2	Албан шаардлага	3	12,600.0	3	12,600.0	100.0
3	Зөвлөмж	4	8,861.7	3	8,861.7	75.0
	<b>Нийт дүн</b>	<b>9</b>	<b>35,337.4</b>	<b>8</b>	<b>35,337.4</b>	<b>88.9</b>

Өмнөх аудитаар зарим зардлыг бүлэг хооронд шилжүүлэн зарцуулсан зөрчилд зөвлөмж өгснийг хэрэгжүүлээгүй тул албан шаардлага хүргүүлэв.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар илэрсэн дараах асуудлуудыг дээд шатны төсөв захирагчийн болон дараагийн аудитаар анхаарал хандуулах шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

1. Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын хавсралтад заасан санхүүгийн тайлангийн маягыг тодорхой болгож сайжруулах талаар эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлэх;
2. Тус байгууллагын эзэмшлийн Баянгол дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах нэгж талбарын 1681000442 дугаартай 1261м<sup>2</sup> талбай бүхий газарт 96 айлын орон сууцыг ажилчдын урьдчилгаа төлбөр болон гүйцэтгэгчийн хөрөнгөөр барьж 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр Улсын комисс хүлээж авч барилга байгууламжийг ашиглалтад оруулах шийдвэр гарсан байна. Тус газар нь анх конторын зориулалттай байсныг 2017 онд 1 дүгээр давхарт цэцэрлэг, 2-3 давхарт Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн болон Далайн захиргааны оффис, дээд давхруудад албан хаагчдын орон сууц байхаар, 2025 оны 05 сарын 15-ны өдөр 9 ба түүнээс дээш давхар нийтийн орон сууцны зориулалттай болгон өөрчилсөн байна. Тайлант онд тус газрын төлбөрт 781.8 мянган төгрөгийг төсвөөс төлсөн байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 176,640.1 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

*Залруулсан алдаа:*

- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөөний дүн 116,145.2 мянган төгрөгөөр зөрүүтэй, төсвийн гүйцэтгэлийн дүнд улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн 44,273.0 мянган төгрөгийг оруулан тайлагнасан;
- Богино хугацаат өр төлбөрийн тодруулгад цалингийн авлагын үлдэгдэл 53,756.2 мянган төгрөг, НДШ-ийн өр төлбөрийн үлдэгдэл 58,230.1 мянган төгрөгийг хааж зөрүүгээр нь 4,473.9 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлээр тайлагнасан;
- Үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн хэсэгт дахин үнэлсэн үндсэн хөрөнгийн элэгдлийн 1,451.0 мянган төгрөгийг тайлагнасан;
- Ланд круйзер 200 /5608УНУ/ маркийн автомашины хуримтлагдсан элэгдлийг тогтоолд зааснаас 813.8 мянган төгрөгөөр илүү бүртгэж, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогын дүнг дутуу тайлагнасан.

Эдгээр алдаа нь УСНББОУС-1 болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 заалттай нийцэхгүй, үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 5,558.5 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэнд 1 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 5,558.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 5,079.1 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

### 5.1 Албан шаардлага

#### 1. Зардлын ангилалтай холбоотой

Тайлант онд 5,558.5 мянган төгрөгийн ажил гүйлгээг зардлын бүлэг хооронд шилжүүлэн зарцуулсан, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;”, 22.1-т “Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана.”, 22.5-д “Төсвийн ангиллын зүйлд санаатайгаар буруу мэдээлэл оруулж төсвийн орлого, зарлагын хэмжээг өөрчлөхийг хориглоно.”41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах, төсвийг бүлэг хооронд шилжүүлэн зарцуулсан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

#### Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглаж байгаа 115,119.5 мянган төгрөгийн дансны үнэ бүхий хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-д “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн ТӨБЗГ-т ирүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасантай тус тус нийцээгүй байна.

#### Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлэн бүртгэлд тусгах арга хэмжээ авах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Төмөр замын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн аудитын тайлан

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөөний дүн 116,145.2 мянган төгрөгөөр зөрүүтэй, төсвийн гүйцэтгэлийн дүнд улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн 44,273.0 мянган төгрөгийг оруулан тайлагнасан байна.	1	116,145.2	-	-	1	116,145.2	1	116,145.2	-	-	-	-
2	Богино хугацаат өр төлбөрийн тодруулгад цалингийн авлага /53,756.2 мянган төгрөг/, НДШ-ийн өглөг /58,230.1 мянган төгрөг/-ийг нэгтгэж зөрүүгээр нь 4,473.9 мянган төгрөгийн өглөгөөр тайлагнасан байна.	1	58,230.1	-	-	1	58,230.1	1	58,230.1	-	-	-	-
3	Үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн хэсэгт дахин үнэлсэн үндсэн хөрөнгийн элэгдлийн 1,451.0 мянган төгрөгийг тайлагнасан байна.	1	1,451.1	-	-	1	1,451.1	1	1,451.1	-	-	-	-
	Шилжүүлэн авсан Ланд круйзер 200 /5608УНУ/ маркийн автомашины хуримтлагдсан элэгдлийг тогтоолд зааснаас 813.8 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн байна. Үүнтэй холбоотойгоор үнэ төлбөргүй хүлээн авсан орлогын дүнг дутуу тайлагнасан байна.	1	813.8	-	-	1	813.8	1	813.8	-	-	-	-
	<b>Дүн</b>	<b>4</b>	<b>176,640.2</b>	-	-	<b>4</b>	<b>176,640.2</b>	<b>4</b>	<b>176,640.2</b>	-	-	-	-

Төмөр замын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн аудитын тайлан

**6.2. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Тайлант онд 5,558.5 мянган төгрөгийн ажил гүйлгээг зардлын бүлэг хооронд шилжүүлэн зарцуулсан, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	1	5,558.5	-	-	1	5,558.5	-	-	-	-	-	-
3	Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглаж байгаа 115,119.5 мянган төгрөгийн дансны үнэ бүхий хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
	<b>Дүн</b>	<b>2</b>	<b>5,558.5</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>5,558.5</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

**6.3. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 496,691.4 мянган төгрөгийн 4 гүйлгээг мэдээлээгүй байна.	1	496,691.4	-	-	1	496,691.4	-	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>496,691.4</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>496,691.4</b>	<b>-</b>	<b>-</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 409/А0150053

Улаанбаатар хот

САГ - 2026/213/НА - СТА - ТШЗ

Зөрчлийг таслах зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төмөр замын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 5,558,480.00 /Таван сая таван зуун тавин найман мянга дөрвөн зуун наян/ төгрөгийн ажил гүйлгээг зардлын бүлэг хооронд шилжүүлэн зарцуулсан, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана.", 22.5-д "Төсвийн ангиллын зүйлд санаатайгаар буруу мэдээлэл оруулж төсвийн орлого, зарлагын хэмжээг өөрчлөхийг хориглоно." 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.10. аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол;" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, төсвийг бүлэг хооронд шилжүүлэн зарцуулдаг зөрчлийг таслан зогсоох, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төмөр замын газрын даргын албан үүрийг түр орлон гүйцэтгэгч /Б.Артур/, ерөнхий нягтлан бодогч /С.Золзаяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:  
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АККАУНТ ТРАСТ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ  
П.НАРАНЦЭЦЭГ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 410/A0150053

Улаанбаатар хот

САГ - 2026/213/НА - СТА - ТШЗ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төмөр замын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 496,691,400.00 /Дөрвөн зуун ерэн зургаан сая зургаан зуун ерэн нэгэн мянга дөрвөн зуун/ төгрөгийн 4 гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална, 4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11.хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулдаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төмөр замын газрын даргын албан үүрийг түр орлон гүйцэтгэгч /Б.Артур/, ерөнхий нягтлан бодогч /С.Золзаяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АККАУНТ ТРАСТ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ  
П.НАРАНЦЭЦЭГ



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-72.Docx

1526180876